



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/493

Арвайхээр

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд 1 өрөө байр худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх  
Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах  
ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: - Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон  
нутгийн өмчийн худалдан авах ажиллагаа  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: А.Баяндүүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн  
газрын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Ш.Авирмэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)  
Д.Уранцэцэг (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын  
албаны төсөв, санхүүгийн ажилтан)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-т даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100803